



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2007 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 194

Улаанбаатар хот

“Даатгалын үнэлгээ хийх аргачлал” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 14.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос **ТОГТООХ** нь:

1. “Даатгалын үнэлгээ хийх аргачлал”-ыг хавсралтаар баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1. Даатгагч, даатгуулагч талууд даатгалын үнэлгээгээ харилцан тохиролцоно.
- 1.2. Даатгалын үнэлгээг төгрөг (валют)-өөр үнэлж даатгалын гэрээ байгуулж болно.
- 1.3. Даатгалын үнэлгээг гадаад валютаар тооцож хийсэн нөхцөлд тухайн үеийн Монголбанкны ханшаар шилжүүлж даатгалын гэрээнд тусгана.

ХОЁР. Эд хөрөнгийн даатгалын үнэлгээ

- 2.1. Эд хөрөнгийг даатгахдаа өөрийн өртөг, зах зээлийн үнийг баримтлан даатгагч, даатгуулагч нар харилцан тохирч даатгалын үнэлгээг тогтооно.
- 2.2. Даатгуулж буй эд хөрөнгийг үзэж, даатгалын үнэлгээний хэмжээг даатгагч газар дээр нь шалгаж энэ журмын 1.1-д зааснаар тогтоож болно.
- 2.3. Эд хөрөнгийн даатгалын үнэлгээний хэмжээ нь тухайн хөрөнгийн өөрийн өртөг эсвэл зах зээлийн үнээс илүүгүй байна.
- 2.4. Тухайн эд хөрөнгийг өөрийн өртөг, зах зээлийн үнээс илүү өндөр үнээр үнэлж даатгасан нөхцөлд даатгалын үнэлгээний илүү хэсгийг даатгагч хүчингүйд тооцно.
- 2.5. Даатгагч байгууллага, иргэдийн эд хөрөнгийг үндэслэлгүйгээр хэт багаар үнэлж даатгахыг хориглоно.
- 2.6. Эд хөрөнгөө зах зээлийн үнэ болон өөрийн өртгөөс өндрөөр үнэлж даатгахыг даатгуулагч нарт хориглоно.

ГУРАВ. Амь нас эрүүл мэндийн даатгалын үнэлгээ

- 3.1. Иргэд өөрийн амь нас, эрүүл мэндээ мөнгөн дүнгээр үнэлж, даатгагчтай харилцан тохиролцсоны үндсэн дээр даатгуулна.
- 3.2. Даатгагч нь даатгалын гэрээнд иргэдийн амь нас, эрүүл мэндийн даатгалын үнэлгээний дээд хязгаар буюу хохирлын нөхөн төлбөрийн хэмжээний талаар заалт оруулж болно.

3.3. Даатгуулагч нь даатгалын гэрээнд заасан даатгалын үнэлгээний дээд хязгаарын дотор, эсвэл эрх бүхий байгууллагаас тогтоосон дээд хязгаарт багтаан даатгагчидтай харилцан тохиролцож даатгуулна.

3.4. Иргэдийн амь нас, эрүүл мэндэд учирсан гэм хортой холбоотой хохирлын нөхөн төлбөрийн хэмжээ нь энэ журмын 3.1-д заасан хэмжээгээр хязгаарлагдана, харин даатгалын үнэлгээнээс давсан нөхцөлд Иргэний хуулийн 505, 508 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

ДӨРӨВ.Хариуцлагын даатгалын үнэлгээ

4.1. Иргэд, байгууллага бусдын өмнө хүлээх өөрийн хариуцлагаа үнэлж даатгагчтай харилцан тохиролцож даатгуулна.

4.2. Даатгагч нь иргэд, байгууллагатай хийх хариуцлагын даатгалын гэрээнд хариуцлагын даатгалын үнэлгээний дээд, доод хязгаарыг зааж болно.

ТАВ.Санхүүгийн болон үйл ажиллагааны даатгалын үнэлгээ

5.1. Даатгагч, даатгуулагч нар үндсэн үйл ажиллагааны зардлыг үндэслэн даатгалын үнэлгээг харилцан тохиролцож тогтооно.

5.2. Даатгалын гэрээнд зардалд оруулж тооцохгүй зүйлийг тодорхой зааж болно.

ЗУРГАА. Бусад

6.1. Даатгуулагч даатгалын үнэлгээг (ашиг олох зорилгоор) санаатайгаар өсгөж хийсэн даатгалын гэрээ хүчин төгөлдөр бус байна.

6.2. Даатгагч зах зээлийн үнэ, даатгалын үнэлгээний зөрүүтэй хураамжийг даатгуулагчид буцааж олгоно.

--ooOoo--